ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын далайн захиргааны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/080/НА-СТА-ТӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalai.d@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Мөнхбилгүүн<br>Утас: 261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК<br>Захирал А.Сарангэрэл Утас: 99884842<br>Цахим хаяг: Gereltekhburtgelaudit3@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.28 № 07/1278
танай ________-ны №__________-т

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.САЙНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8,1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын далайн захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, цалин, урамшууллыг илүү олгосон, зээл олгож, авлага үүсгэсэн, авлага, өр төлбөрийн тооцоог хянаагүй илүү шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгосон нөхөн олговорыг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй зэрэг нийт 707.0 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй болович өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох заавар журам, олон улсын стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 2024 онд нийт 414.4 мянган тн даац бүхий 244 хөлөг онгоц бүртгэж, Ази, Номхон далайн бүс нутагт далайн тээврийн үйл ажиллагаа

явуулдаг бөгөөд тэдгээрт Нэгдсэн Үндэстний Байгууллагын хориг арга хэмжээг зөрчиж байгаа болон аливаа хууль бус үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцнуудыг бүртгэхээс сэргийлэх зорилгоор Олон улсын “Эс энд Пи Глобал” далайн тээврийн эрсдэлээс сэргийлэх бүртгэл, хяналтын мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд "төрийн байгууллага, албан газар" гэж байгууллагын статусыг тодорхойлсон боловч хөлөг онгоцны бүртгэлийн орлого буюу үйл ажиллагааны орлогоос санхүүжиж, Зам тээврийн хөгжлийн сайдын баталсан орлого, зарлагын төлөвлөгөөг баримталж, улсын төсөвт жил бүр орлого төвлөрүүлдэг байна.

**Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 9 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 82.1 хувьтай үнэлэгдсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ATA9693 9006109
9023030583

Z:\Yawsan_Bichig\2025\0325 SNAG-40.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,059,447,661.78** | **5,341,216,290.08** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **6,080,088,454.30** | **4,651,413,001.95** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **6,080,088,454.30** | **4,651,413,001.95** |
| **31210** | **Төгрөг** | **5,113,047,298.84** | **4,650,984,007.86** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 5,113,047,298.84 | 4,650,984,007.86 |
| **31220** | **Гадаад валют** | **967,041,155.46** | **428,994.09** |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 967,041,155.46 | 428,994.09 |
| **33** | **АВЛАГА** | **813,741,533.63** | **584,861,258.14** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 9,707,008.04 | 12,258,009.80 |
| **33500** | **Бусад авлага** | **804,034,525.59** | **572,603,248.34** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 788,576,741.59 | 522,334,684.34 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 15,457,784.00 | 50,268,564.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **13,550,000.00** | **13,550,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 13,550,000.00 | 13,550,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **152,067,673.85** | **91,392,029.99** |
| **35400** | **Хангамжийн материал** | **152,067,673.85** | **91,392,029.99** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 56,491,140.00 | 48,568,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,777,335.00 | 10,777,335.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 936,000.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,687,389.65 | 359,629.99 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 77,175,809.20 | 31,686,865.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,495,647,913.65** | **1,858,086,845.61** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **190,192,000.00** | **190,192,000.00** |
| 37330 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 190,192,000.00 | 190,192,000.00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,116,562,853.65** | **1,667,894,845.61** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,101,334,853.65** | **1,162,057,838.10** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 697,043,130.34 | 905,936,190.34 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (97,996,434.87) | (132,330,936.06) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 760,430,201.74 | 715,203,977.24 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (467,980,922.54) | (484,963,492.71) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 266,961,135.00 | 565,023,835.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (94,700,649.87) | (152,754,593.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,976,952.0 | 83,310,252.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,398,558.15) | (28,459,061.11) |
| 39209 | Бусад үндсэн хөрөнг | - | 193,500,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | - | 22,408,333.40 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **15,228,000.00** | **25,837,007.51** |
| 39301 | Програм хангамж | 11,118,000.00 | 11,118,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,338,000.00) | (10,234,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,448,000.00 | 26,068,294.40 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | 1,115,286.89 |
| **39400** | **Дуусаагүй барилга, байгууламж** | **188,893,060.00** | **-** |
| 39401 | Дуусаагүй барилга, байгууламж | 188,893,060.00 | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,555,095,575.43** | **7,199,303,135.69** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **122,806,969.00** | **128,287,176.93** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **122,806,969.00** | **128,287,176.93** |
| **41300** | **Өглөг** | **122,806,969.00** | **128,287,176.93** |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон | - | 807,540.21 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 13,900,000.00 | 18,163,712.65 |
| **41360** | **Бусад өглөг** | **108,906,969.00** | **109,315,924.07** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 98,911,969.00 | 19,457,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 9,995,000.00 | - |
| 41363 | Татварын өглөг | - | 41,503,469.21 |
| 41364 | НДШ-ийн өглөг | - | 48,355,454,86 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,432,288,606.43** | **7,071,015,958.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **8,432,288,606.43** | **244,784,600.24** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 231,164,305.84 | 244,784,600.24 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 231,164,305.84 | 244,784,600.24 |

| | | | |
|---|---|---|---|
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **8,201,061,840.59** | **6,826,168,898.52** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8,201,061,840.59 | 8,201,061,840.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (1,374,892,942.07) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 62,460.0 | 62,406.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,555,095,575.43** | **7,199,303,135.69** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* *(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,089,526,562.77** | **4,271,634,229.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,089,526,562.77** | **4,270,296,990.75** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **6,089,526,562.77** | **4,270,296,990.75** |
| 12000 | Хүүгийн орлого | 242,125,213.68 | 460,008,770.69 |
| 120009 | Бусад орлого | 36,785,087.73 | 87,224,711.43 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) | 5,810,616,261.36 | 3,723,063,508.63 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **1,337,239.00** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,631,885,020.87** | **5,632,944,804.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,631,885,020.87** | **5,632,944,804.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,220,646,814.72** | **4,495,693,388.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,161,825,002.01** | **1,583,614,698.48** |
| 210101 | Үндсэн цалин | 830,776,774.45 | 1,105,718,683.65 |
| 210102 | Нэмэгдэл | 188,565,477.56 | 230,441,014.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 120,615,000.00 | 211,080,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,867,750.00 | 36,375,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **141,996,398.98** | **188,306,004.43** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,697,982.48 | 135,776,713.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,324,604.19 | 14,932,501.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,059,683.24 | 1,726,595.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,264,920.91 | 6,656,060.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,649,208.16 | 29,214,133.57 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **231,642,307.52** | **254,315,728.82** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,428,307.52 | 1,205,328.82 |
| 210304 | Байрны түрээс | 229,214,000.00 | 253,110,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **199,106,930.51** | **276,945,838.79** |
| 210401 | Бичиг хэрэг | 13,661,775.11 | 27,908,410.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 77,113,091.58 | 87,327,009.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 42,455,946.82 | 40,859,220.17 |
| 210404 | Ном, хэвлэл | 245,180.00 | 6,519,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,946,500.00 | 25,024,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 61,684,437.00 | 89,306,798.82 |
| **2105** | **Нормативт зардал** | **376,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 376,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **43,210,830.00** | **83,443,363.00** |
| 210601 | Багаж, техник , хэрэгсэл | **-** | **110,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 43,210,830.00 | 83,333,363.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **421,162,732.53** | **344,078,445.73** |
| 210701 | Гадаад албан томилолт | 313,467,358.00 | 192,592,657.50 |
| 210702 | Дотоод албан томилолт | 76,183,676.00 | 123,060,145.76 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 31,511,698.53 | 28,425,642.47 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **737,330,011.75** | **1,033,972,879.23** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 637,772,448.98 | 988,807,136.41 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 64,035,618.53 | 7,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,851,510.35 | 12,984,100.35 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 586,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 651,787.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,908,000.00 | 21,500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 29,224.00 | 420,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,081,422.89 | 2,675,042.47 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **283,996,601.42** | **731,016,429.65** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 126,856,016.11 | 518,471,147.21 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,886,000.00 | 25,467,920.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 152,254,585.31 | 187,077,362.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **411,238,206.15** | **1,137,251,416.28** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **91,268,206.15** | **249,388,564.91** |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 91,268,206.15 | 249,338,564.91 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **69,970,000.00** | **632,862,851.37** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 1,337,239.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,300,000.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 960,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 66,710,000.00 | 631,525,612.37 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **250,000,000.00** | **255,000,000.00** |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 250,000,000.00 | 255,000,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **2,457,641,541.90** | **(1,361,310,574.66)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **70,223,745.19** | **7,713,803.03** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 70,223,745.19 | 7,713,803.03 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **515,887,306.42** | **21,296,170.44** |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 515,887,306.42 | 21,296,170.44 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **2,011,977,980.67** | **(1,374,892,942.07)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **231,164,305.84** | **62,460.00** | **6,189,083,859.92** | **6,420,310,625.76** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **231,164,305.84** | **62,460.00** | **6,189,083,859.92** | **6,420,310,625.76** |
| 4 | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | 2,011,977,980.67 | 2,011,977,980.67 |
| 5 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **231,164,305.84** | **62,460.00** | **8,201,061,840.59** | **8,432,288,606.43** |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **13,620,294.40** | | | **13,620,294.40** |
| 7 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| 8 | Тайлант үеийн үр дүн | | | (1,374,892,942.07) | (1,374,892,942.07) |
| 9 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **244,784,600.24** | **62,460.00** | **6,826,168,898.52** | **7,071,015,958.76** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,334,612,306.28** | **4,571,815,729.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,334,612,306.28** | **4,571,815,729.86** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **5,334,612,306.28** | **4,571,815,729.86** |
| 120002 | Хүүгийн орлого | 242,125,213.68 | 447,940,050.20 |
| 120003 | Торгуулийн орлого | - | - |
| 120009 | Бусад орлого | 32,320,340.58 | 133,456,272.74 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 5,060,166,752.02 | 3,990,419,406.92 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,384,963.522.11** | **5,165,669,802.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,384,963,522.11** | **5,165,699,802.73** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,849,146,181.76** | **3,985,039,759.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,166,061,407.19** | **1,367,518,708.57** |
| 210101 | Үндсэн цалин | 1,159,336,157.19 | 1,352,401,708.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,725,250.00 | 15,117,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **142,217,688.26** | **319,035,302.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,697,982.48 | 319,035,302.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,324,604.19 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,059,683.24 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,264,920.91 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,870,497.44 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **227,742,960.49** | **253,110,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,278,960.49 | - |
| 210304 | Байрны түрээс | 226,464,000.00 | 253,110,400.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **135,239,404.45** | **139,359,724.17** |
| 210401 | Бичиг хэрэг | 13,232,123.63 | 17,558,460.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 67,629,450.00 | 58,591,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 42,155,946.82 | 40,833,520.17 |
| 210404 | Ном, хэвлэл | 545,180.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,676,704.00 | 22,376,744.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **376,000.00** | **59,475.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 59,475.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 376,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,585,420.00** | **117,079,073.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,001,900.00 |
| 210602 | Тавилга | 10,874,500.00 | 12,483,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,377,840.00 | 21,725,660.00 |
| 210604 | Урсгал засвар | 48,333,080.00 | 81,868,213.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **427,576,075.53** | **379,503,878.25** |
| 210701 | Гадаад албан томилолт | 311,403,958.00 | 194,270,545.90 |
| 210702 | Дотоод албан томилолт | 89,090,076.00 | 143,284,830.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 27,082,041.53 | 41,948,502.35 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **521,739,545.79** | **1,120,106,317.04** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 446,477,501.13 | 1,068,118,955.41 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 43,189,647.00 | 7,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,975,199.35 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 586,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,704,787.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,613,000.00 | 32,484,100.35 |
| 210807 | Газрын төлбөр | 29,224.00 | 420,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,750,187.31 | 2,420,561.28 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **162,607,680.05** | **289,266,881.77** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 155,022,180.05 | 235,193,301.77 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,585,500.00 | 54,073,580.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **535,817,340.35** | **1,180,630,042.84** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **215,943,340.35** | **292,767,191.47** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 215,943,340.35 | 292,767,191.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **69,874,000.00** | **632,862,851.37** |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 1,337,239.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,650,000.00 | 600,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,864,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,000,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,360,000.00 | 31,525,612.37 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **250,000,000.00** | **255,000,000.00** |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 250,000,000.00 | 255,000,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,949,648,784.17** | **(593,854,072.87)** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН IV** | **42,700,909.78** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 145001 | Валютийн ханшийн зөрүү | 42,700,909.78 | - |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **372,880,770.00** | **819,913,523,35** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **372,880,770.00** | **819,913,523,35** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **372,880,770.00** | **819,913,523,35** |
| 220001 | Барилга байгууламж | 28,614,450.00 | 102,403,573.35 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 116,958,800.00 | 649,470,550.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 67,028,910.00 | 68,039,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 160,278,610.00 | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(372,880,770.00)** | **(819,913,523.35)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **-** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 42,700,909.78 | 14,907,856.13 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **1,619,468,923.95** | **(1,428,675,452.35)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,460,619,530.35 | 6,080,088,454.30 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 6,080,088,454.30 | 4,651,413,001.95 |

## 2.5 Орлого зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | 2023 оны гүйцэтгэл | 2024 оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| А | Хөлөг онгоцны бүртгэлийн орлого | 5,810,616.2 | 4,140,000.0 | 3,990,419.4 | (149,580.6) | 96.3 |
| Б | Техник хяналт гэрчилгээний орлого | 4,329.5 | 3,500.0 | 4,607.0 | 1,107.0 | 131.0 |
| В | Хадгаламжийн хүүгийн орлого | 242,125.2 | - | 447,940.1 | 447,940.1 | 100.0 |
| Г | Бусад орлого | 32,320.3 | 105,280.0 | 128,849.3 | 23,569.3 | 122.0 |
| **Нийт орлогын дүн** | | **6,089,391.3** | **4,248,780.0** | **4,571,815.7** | **323,035.7** | **107.0** |
| 1 | Цалин хөлс | 897,827.8 | 1,494,550.0 | 1,352,401.7 | 142,148.3 | 9.00 |
| 2 | Цалингийн нэмэгдэл, урамшуулал | 268,269.4 | 162,940.8 | - | 162,940.8 | - |
| 3 | Нийгмийн даатгалын шимтгэл | 142,217.7 | 207,186.4 | 319,035.3 | (111,848.9) | 153.9 |
| 4 | Бичиг хэргийн зардал | 13,232.1 | 13,718.0 | 17,558.5 | (3,840.5) | 128.0. |
| 5 | Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс | 11,676.7 | 16,060.0 | 22,376.7 | (6,316.7) | 139.3 |
| 6 | Эд хогшил, урсгал засварын зардал | 65,585.4 | 71,000.0 | 81,868.2 | (10,868.2) | 115.3 |
| 7 | Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/ | 227,743.0 | 273,528.0 | 253,110.4 | 20,417.6 | 92.5 |
| 8 | Ном, хэвлэл | - | - | - | - | |
| 9 | Шатахууны зардал | 67,629.5 | 81,380.0 | 58,591.0 | 22,789.0 | 72.0 |
| 10 | Даатгалын зардал | - | 1,350.0 | - | 1,350.0 | - |
| 11 | Утас, интернэтийн зардал | 42,155.9 | 61,649.6 | 40,833.5 | 20,816.1 | 66.2 |
| 12 | Томилолтын зардал /унаа, буудал, хоол/ | 427,576.1 | 495,004.8 | 379,503.9 | 115,500.9 | 76.7 |
| 13 | Бусад зардал | 921.2 | - | - | - | - |
| 14 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал | 69,874.0 | 632,000.0 | 631,525.6 | 474.4 | 99.9 |
| 15 | Банкны үйлчилгээний зардал | - | 2,500.0 | 2,420.6 | 79.4 | 96.8 |
| 16 | Хөрөнгө оруулалт | 372,880.8 | 3,194,280.7 | 819,913.5 | 2,374,367.2 | 25.6 |
| 17 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 250,000.0 | 300,000.0 | 255,000.0 | 45,000.0 | 85.0 |
| 18 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 521,739.5 | 1,221,610.0 | 1,120,106.3 | 101,503.7 | 91.6 |
| 19 | Бараа үйлчилгээний бусад зардал | 144,742.7 | 356,309.7 | 289,266.9 | 67,042.8 | 81.1 |
| 20 | Сургалтын зардал | 17,865.0 | 84,130.3 | 54,073.6 | 30,056.7 | 64.2 |
| 21 | Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох | - | 12,800.0 | 7,000.0 | 5,800.0 | 54.6 |
| 22 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 215,943.3 | 298,933.6 | 292,767.2 | 6,166.4 | 97.9 |
| **Нийт зардлын дүн** | | **3,757,880.1** | **8,980,931.9** | **5,997,352.9** | **2,983,579.0** | **77.6** |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 198,701.4 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөлөг онгоцны бүртгэлийн орлоготой холбоолтой авлагыг сөрөг утгаар тайлагнасан | 1 | 198,701.4 | - | - | 1 | 198,701.4 | 1 | 198,701.4 | - | - | - | - |
| | **Дүн** | **1** | **198,701.4** | **-** | **-** | **1** | **198,701.4** | **1** | **198,701.4** | **-** | **-** | **-** | **-** |

**3.2** Аудитаар нийт 706,972.4 мянган төгрөгийн 10 зөрчил[2] илэрснээс, 49,006.6 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 627,965.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгч, 30,000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | НДШ-ийн хувь хэмжээг буруу тооцож, цалинг илүү олгосон | 1 | 926.6 | 1 | 926.6 | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон | 1 | 3.080.0 | 1 | 3.080.0 | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Улсын төсөвт орлогыг дутуу төвлөрүүлсэн | 1 | 45,000.0 | 1 | 45,000.0 | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Цалин зээл 1 жил хүртэл хугацаагаар олгож, авлага үүсгэсэн | 1 | 12,258.0 | - | - | 1 | 12,258.0 | - | - | - | - | - | - |
| 5 | Ажил гүйцэтгэсэн төлбөрийг илүү шилжүүлсэн | 1 | 250.0 | - | - | 1 | 250.0 | | | | | | |
| 6 | Орон сууцны дэмжлэг олгохдоо анхан шатны бүрдэл дутуу баримтыг үндэслэн олгосон | 1 | 600,000.0 | - | - | 1 | 600,000.0 | - | - | - | - | - | - |
| 7 | Буруутай албан тушаалтнаар байгууллагад учирсан хохирлыг төлүүлээгүй | 2 | 45,457.8 | - | - | 1 | 15,457.8 | 1 | 30,000.0 | - | - | - | - |
| 8 | Хөлөг онгоцны бүртгэлийн орлого 96.4 хувийн биелэлттэй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| 9 | Хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй олж бэлтгэсэн | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | **Дүн** | **10** | **706,972.4** | **3** | **49,006.6** | **4** | **627,965.8** | **3** | **30,000.0** | **-** | **-** | **-** | **-** |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 6,105,377.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | 6,105,377.1 | - | - | 1 | 6,105,377.1 | - | - |
| | Дүн | 1 | 6,105,377.1 | - | - | 1 | 6,105,377.1 | - | - |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2 | Байгууллагын хаиуцлагын хэлбэрийг тодорхой болгох талаар дээд шатны байгууллага шийдвэрлээгүй | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| 3 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуух зарим ажил хэрэгжээгүй | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| | Дүн | 2 | - | - | - | 1 | - | 1 | - |
| | **Нийт дүн** | **3** | **6,105,377.1** | **-** | **-** | **2** | **6,105,377.1** | **1** | **-** |